



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны
удирдлагын тогтолцооны журам

Аюултай материалын менежментийн журам

Аюултай материалын менежментийн журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.06.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E5-PRC-0001-M	Хувилбар: 2.0

1 ЗОРИЛГО

Ажилчид болон байгаль орчинд үзүүлэх Аюултай материалын (түүнчлэн Аюултай бараа бүтээгдэхүүний) нөлөөг бууруулах зорилгоор Аюултай материалын ашиглалт, үр дүнтэй менежментийн шаардлагуудыг тодорхойлох, хууль тогтоомж, төслийн шаардлагуудын (Рио Тинтогийн стандарт, БОННУ-ний шаардлагууд г.м) хэрэгжилтийг хангах

2 ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ

Энэхүү Журам нь Оюу Толгой ХХК-ын (ОТ) болон түүний нэрийн өмнөөс удирдаж буй аливаа ажлын талбайд үйлчилнэ.

3 АЖИЛ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Ажил үүрэг	Хариуцлага
Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны менежерүүд	<ul style="list-style-type: none"> ОТ-н хэлтсүүд, гэрээт гүйцэтгэгчдэд Аюултай материалын менежментийн талаар техникийн туслалцаа үзүүлэх Энэхүү журмын Аюултай материалын менежментийн шаардлагуудын хэрэгжилтийг хянах үе шатны хяналт, шалгалтыг хийхэд шаардлагатай нөөцийг бий болгох Энэхүү журамыг баталж, бүх ажилчид, гэрээт гүйцэтгэгчдэд хүртээх Тухайн бодисыг ОТ-д ашиглахын өмнө үнэлж, батлахад удирдлага болгон ашиглах Аюултай материалыг батлах журмыг тодорхойлох ОТ-н стандарт, төлөвлөгөө, журам зэргийг хууль тогтоомж болон төслийн шаардлагуудын дагуу тодорхойлох
Оюу Толгойн хэлтсийн болон гэрээт гүйцэтгэгчдийн менежерүүд	<ul style="list-style-type: none"> Аюултай материалыг энэхүү журамд тодорхойлсон шаардлагуудын дагуу удирдан зохицуулах Аюултай материалыг энэхүү журмын шаардлагуудын дагуу батлах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах Аюултай материалын агуулахад Хор аюулын лавлах мэдээллийг байршуулах Гэрээт гүйцэтгэгчийн ЭМААБО-ны менежментийн төлөвлөгөө нь гэрээт гүйцэтгэгчийн удирдлагын хүрээнд энэхүү журамд нийцсэн байна
Ажлын байрын ЭМААБО-ны ахлах ажилтнууд/мэргэжилтнүүд	<ul style="list-style-type: none"> Аюултай материалын хадгалалт болон ашиглалтын ноцтой эрсдэл бүхий ажлын байранд тогтмол шалгалт хийх Аюултай материал байгаа газарт Хор аюулын лавлах мэдээллийг Монгол болон Англи хэл дээр байршуулах
Сургалтын хэлтсийн менежерүүд	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай гэж үзсэн хүмүүст Аюултай материалын менежментийн ажиллагааны талаар сургалт явуулах
Хангамжийн хэлтсийн	<ul style="list-style-type: none"> "ОТ-E5-GDL-0001- Аюултай материалын зөвшөөрөл олгох журам"-ын дагуу Аюултай материалыг хангах буюу уг журмын дагуу

Аюултай материалын менежментийн журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.06.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е5-PRC-0001-М	Хувилбар: 2.0

менежерүүд	аюултай материалыг ханган нийлүүлэхээс өмнө түүний эрсдэл, ашиглалт, хадгалалт, устгах үйл явц зэрэгт үнэлгээ өгнө.
Бүх ажилчид, гүйцэтгэгчид	<ul style="list-style-type: none"> Аюултай материалтай холбоотой осол зөрчлийг ЭМААБО-ны осол зөрчил болгон мэдээлнэ Аюултай материалыг энэхүү журамд заасан шаардлагын дагуу удирдан зохицуулах

4 ЖУРАМ

4.1 Ерөнхий

Аюултай материалын менежментэд дараах ерөнхий шаардлагуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Аюултай материалыг ашиглах, түүнтэй харьцахад шаардлагатай бүх зөвшөөрлийг Монгол улсын зохих ёсны төрийн байгууллагаас авсан. Мөн химийн бодисыг төслийн талбайд авчрахдаа *ОТ-Е5-GDL-0001-Е “Аюултай материалын зөвшөөрөл олгох журам”-ыг* баримтална.
- Тэргүүлэх ач холбогдолтой тодорхой нэгэн материалд зориулсан тусгай журам, сургалтын шаардлага зэргийг эрсдлийн үнэлгээний дагуу боловсруулна.
- Хортой болон аюултай материал ашиглаж байгаа хэлтсүүд нь Аюултай материалын менежментийг явуулах, зөвлөгөө өгөх ажилтныг томилно.

4.2 Аюултай материалтай ажиллах

ОТ-д Аюултай материалтай харьцахад дараах шаардлагыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Аюултай материалыг тээвэрлэхэд ашиглах бүх тоног төхөөрөмжийг Хэлтсийн менежер тодорхойлж, тээвэрлэлттэй холбоотой аливаа эрсдлийг бүрэн хянах зорилгоор эрсдлийг үнэлнэ.
- Их хэмжээний аюултай шингэн хадгалах газар, эсхүл аюултай шингэн их хэмжээгээр ашиглах газарт цэвэрлэгээний иж бүрдэл, хамгаалах төхөөрөмж, бусад шаардлагатай төхөөрөмжийг байрлуулна.
- Аюултай материалтай харьцах үедээ холбогдох Хор аюулын лавлах мэдээлэл, Аюултай материалын зөвшөөрөлд заасан Хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ), гал хамгаалах төхөөрөмжийг ашиглана.
- Урсгал ус, худаг, цөөрмийн ойролцоо Аюултай материалтай харьцах, хадгалахаас зайлсхийх.
- Асгаралтын үеийн хариу арга хэмжээний талаар илүү дэлгэрэнгүй зааварчилгааг *ОТ-ENV-PR-045 “ОТ-н Асгаралтын эсрэг авах хариу арга хэмжээний журам”-аас* авна уу.

4.3 Аюултай материалыг тээвэрлэх

ОТ-д Аюултай материалыг тээвэрлэхэд дараах шаардлагыг мөрдөнө. Үүнд:

- Гал унтраагч, галаас урьдчилан сэргийлэх материал, асгаралтаас урьдчилан сэргийлэх материал зэрэг нь Аюултай материалын зөвшөөрөлд тодорхойлсон хяналтын арга хэмжээний дагуу, тухайн тээвэрлэгдэж буй Аюултай материалтай таарч тохирсон байна;
- Тухайн тээвэрлэгдэж буй материалд таарч тохирохуйц савыг Хэлтсийн менежерийн тодорхойлсноор ашиглах;

Аюултай материалын менежментийн журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.06.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E5-PRC-0001-M	Хувилбар: 2.0

- Аюултай материалыг агуулж буй савыг тээвэрлэгдэхээс өмнө зохих ёсоор хамгаалсан байна.
- Хор аюулын лавлах мэдээлэл, Аюултай материалын зөвшөөрөлд заасны дагуу тухайн сав болон ачааны машиныг тэмдэглэж, анхааруулга болон зурагт хуудас наана.
- *ОТ-E5-GDL-0001-E “Аюултай материалын зөвшөөрөл олгох журам”- д* заасан Монгол улсын зохицуулалтын дагуу Химийн бодисын бүртгэл хөтлөнө.
- ОТ нь Аюултай материалтай харьцах, тээвэрлэх байгууллагыг сонгон шалгаруулахдаа шаардлагад нийцэж байгаа эсэхийг нь баталгаажуулна. Аюултай материалын тээвэрлэлийн аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон ажилтан (цувааг хариуцсан ахлах ажилтан) нь аюултай болон хортой материалын тээвэрлэлтийг зөвшөөрөгдсөн замаар, замын хөдөлгөөний дүрэм журмын дагуу зохицуулна.

4.4 Аюултай материалыг хадгалах

4.4.1 Тоног төхөөрөмжөөр хангах

ОТ-н Аюултай материалыг хадгалах талбайг тоноглоход дараах шаардлагыг баримтална. Үүнд:

- Асгаралыг цэвэрлэх, багасгах зорилгоор шингэн цэвэрлэгээний иж бүрдэл, хамгаалах төхөөрөмж, бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг ажлын талбайд байрлуулна.
- Асгарах аюул эрсдэл бүхий, гэмтэлтэй савыг ашиглахгүй бөгөөд түүнийг Ажлын байрны менежер буюу ахлах ажилтан актална.
- Аюултай материалыг хадгалах талбайн ойролцоо гал унтраах зохих тоног төхөөрөмжийг байршуулна.
- Хадгалалтын төлөвлөгөөнд тодорхойлсон яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийг цаг ямагт бэлэн байлгана.
- Анхны тусламжийн хайрцгийг (шаардлагатай бол нүд угаах шингэн) Аюултай материал хадгалах талбайн ойролцоо байршуулна.
- ОТ нь дээрх бүгдийг ойлгуулах, Аюултай материалаас хүн болон байгаль орчинд учруулж болзошгүй аюулыг бууруулах зохистой арга хэмжээг бий болгох зэрэг зорилгоор өөрт байгаа болон өөрийн бий болгосон Аюултай материалын бүртгэлийг хөтлөнө. Үүнд: хадгалагдаж буй бүх материалын Хор аюулын лавлах мэдээллийг (ХАЛМ) гаргах, болзошгүй радио идэвхт материалыг тусгаарлах талаар нарийвчлал гаргах зэрэг багтана. ХАЛМ нь Монгол болон Англи хэл, түүнчлэн шаардлагатай бусад хэл дээр байж болно.
- Хадгалалтын талбай нь бүртгэлийн дэвтэртэй байна. Бүртгэлийн дэвтэрт тухайн хадгалагдаж буй бодисын төрөл, ангилал, нэр, тоо хэмжээ зэргийг бичиж тэмдэглэнэ.

4.4.2 Аюултай материалыг хадгалах талбайн зураг төсөл

Аюултай материалыг хадгалах талбайн зураг төсөлд дараах шаардлагыг мөрдөнө. Үүнд:

- Аюултай шингэн материалыг хадгалахдаа (хаягдал тос, уусгагч, г.м) хаягдал шингэний багтаамжийн 110%-тай тэнцэх багтаамжтай нэг бүрийн хашилт, эсвэл нийт хаягдал шингэний эзлэхүүний 25%-тай тэнцэх багтаамж бүхий нэгдсэн хашилтын аль илүү багтаамжтайг нь сонгоно.

Аюултай материалын менежментийн журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.06.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е5-PRC-0001-М	Хувилбар: 2.0

- Хадгалалтын талбай нь Төсөлд шаардагдах Аюултай материалыг хадгалахад хүрэлцээтэй байхаар зохион бүтээгдсэн байна. Үүнд хадгалалтын талбайд нэвтрэх хяналт (шаардлагатай бол), эрсдлийн үнэлгээнд тодорхойлсон амрах байр / ажлын талбайгаас хангалттай их зайд байгууламжийг байршуулах зэрэг асуудал хамаарна.
- Хадгалалтын талбай нь аюулгүй нэвтрэх болон хадгалах савтай ажиллахад хангалттай зайтай байхаар тооцож зохион бүтээгдсэн байна.
- Хадгалалтын талбай нь байгаль орчны бохирдол, ялангуяа хөрс, газрын доорх усны бохирдлыг хязгаарлах, түүнээс урьдчилан сэргийлэх боломжтой байна.
- Холбогдох хадгалах байгууламжийн эрсдлийн үнэлгээний дагуу хадгалагдаж буй материалд таарч тохирох, хангалттай хэмжээнд галаас урьдчилан сэргийлэх системийг суулгасан байна.
- Материалын хадгалах талбайгаас гарах гадаргын болон хур тунадасны усыг тос баригч болон тунадас цуглуулагч руу чиглүүлнэ.
- Ууршигтай аюултай материалыг хадгалах талбай нь тэсрэх болон хортой бохирдуулагч бодис агаарт хуримтлагдахаас сэргийлэх агааржуулагчаар тоноглогдсон байна.
- Хадгалалтын талбайд хоорондоо харшлах материалыг тусгаарлах зорилгоор хана, далан, хашлага зэргийг ашиглана.

4.4.3 Агуулах талбайн одоогийн менежмент

ОТ-д хадгалагдаж буй аюултай материалд дараах ашиглалтын шаардлагыг мөрдөнө. Үүнд:

- Аюултай материалыг хадгалах талбайд зөвхөн Ажлын байрны менежер буюу Ахлах ажилтны тодорхойлсон зөвшөөрөлтэй албан хаагчид нэвтрэнэ.
- Хэрэглэж буй, худалдаж авсан, эсхүл ажлын талбайд байгаа материалын нарийн сонголт хийх, хяналт хийх, мөн материалын нөөц бүртгэх замаар Аюултай материалын нийт хэмжээг аль болох бага хэмжээнд байлгана. Материалын хяналтыг хийснээр бүх худалдаж авсан материалыг хадгалах хангалттай зай талбай байгаа эсэхийг нягтлах боломжтой болно.
- 500 тонноос илүүгүй химийн бодисыг нэг байранд хадгалах бөгөөд өрөө тус бүрт 50 тонноос илүүгүй байна.
- Хаягдал тосыг газар дорх саванд удаан хугацаагаар хадгалахыг хориглоно. Газар дорх танк, савыг тогтмол хугацаанд суллаж, ямар нэгэн цууралт үүссэн, нүх гарсан шинж тэмдэг байгаа эсэхийг шалгана. Шалгалтаар гарсан үр дүнг тэмдэглэж хадгалах бөгөөд цууралт болон нүх гарсныг засварлаж, бүртгэл хөтөлнө.
- Хоорондоо харшлах материалуудыг (ж.нь: хүчил болоншүлт) нэг саванд хадгалахгүй бөгөөд осол аваараас урьдчилан сэргийлэх аюулгүй байдлаар, аюулгүй зайд хадгална.
- Материалын эрсдлийн үнэлгээний дагуу тодорхойлсон хоорондоо харшлах материалуудыг зохих арга замаар тусгаарлана. (тусгай талбай, хана, далан, хашлага, тусдаа байгууламж)
- Ажлын байрны менежер эсхүл Ахлах ажилтан нь үе шатны шалгалтаар далангийн хүчин чадал, ажиллагаанд хяналт тавьж, баталгаажуулна.
- Ажлын байрны менежер нь хаалт бүхий талбайгаас зайлуулсан усыг бохирдсон хаягдал ус гэж үзэх бөгөөд хаягдал гэсэн утгаар зохицуулна.
- Аюултай материал хадгалах талбайд галын эс үүсвэрийг хориглох (“тамхи татахыг хориглоно” тэмдэглэгээ тавих г.м), галаас урьдчилан сэргийлэх болон галын менежментийн туршлагыг тухайн талбайд явуулсан эрсдлийн үнэлгээний дагуу боловсруулна.

Аюултай материалын менежментийн журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.06.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е5-PRC-0001-М	Хувилбар: 2.0

- Аюултай материалыг хадгалах зориулалттай торх, сав, хадгалах талбайд тусгай шошго нааж, ХАЛМ-ээр хангаж (Англи, Монгол, шаардлагатай бусад хэл дээр), тэмдэг болон зурагт хуудас байршуулж, хамгаалсан байна. Савнуудыг тусгайлсан далан бүхий хадгалалтын талбай буюу агуулахад, тусгай тавиур дээр байршуулна.

4.5 Тэсрэх материалууд

Тэсрэх аюултай материалын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтанд дараах шаардлагыг мөрдөнө. Үүнд:

- Ажлын талбай дахь тэсрэх аюултай материалын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтыг тусгай сургалтад хамрагдаж, мэргэшсэн хүн явуулна. Сургалт, мэргэшүүлэх сургалтыг баталгаажуулах ажлыг Сургалтын хэлтсийн менежер тодорхойлно.
- Тэсрэх аюултай материалтай ажилладаг бүх ажилтан нь Сургалтын хэлтсийн менежерийн тодорхойлсон журмын дагуу гал унтраагуурыг хэрхэн ашиглах талаар, мөн асгаралтын эсрэг авах арга хэмжээний талаарх сургалтанд хамрагдана.
- Тэсрэх бодис ашиглаж буй томоохон эрсдэл бүхий үйл ажиллагаанд тусгай журам хэрэгжүүлнэ. (ашигласан буюу илүүдэл тэсрэх бодистой харьцах, тээвэрлэх, хадгалах, цэнэглэх, тэслэх, устгах)

4.6 Тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ

- Тосоор дүүргэсэн цахилгаан хэрэгслийг галын аюулгүй, найдвартай нөхцөлд хадгална.
- Байгаль орчныг бохирдуулахаас сэргийлэх зорилгоор тоног төхөөрөмж, үйлдвэр, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг тусгайлсан зориулалтын газар хийнэ.
- Шатахуун, тос, тосолгооны бүтээгдэхүүнээр ажилладаг бүх суурин тоног төхөөрөмжийн дор зориулалтын тосгуур тавина. (генератор, хөдөлгөөнт гэрэлтүүлэг цамхаг, насос, г.м)
- Цистерн, машин механизмыг хэмжих багажаар тоноглож, хальж асгарахаас хамгаална. (ж.нь: түвшний хэмжигч, аваарын хавхлагууд, хальж асгарахаас хамгаалах хавхлага, гэнэтийн ослын хаалт)

4.7 Тайлагнах

ОТ-н Байгаль орчны хэлтэс улирлын тайланг боловсруулах бөгөөд үүнд дараах орно:

- Тайлант хугацааны туршид явуулсан үйл ажиллагааны дүгнэлт
- Энэхүү Менежментийн төлөвлөгөөг ноцтойгоор зөрчсөн, эсхүл биелүүлээгүй тохиолдол
- Дараачийн тайлант хугацаанд явуулах үйл ажиллагаа
- Анхаарал татаж буй бусад асуудал

Хяналт шалгалт, аудит, осол зөрчлийн мэдээллээр илрүүлсэн зөрчлийг ОТ-н ЭМААБО-ны Гүйцэтгэлийн үнэлгээний журмын хүрээнд дотооддоо тайлагнана.

Аюултай материалын менежментийн журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.06.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е5-PRC-0001-М	Хувилбар: 2.0

5 ТОДОРХОЙЛОЛТ

Аюултай материал: Аюултай материал гэдгийг хүний эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой хор уршиг тарьж болох (хатуу, шингэн эсвэл хийн төлөвт байгаа) ямар нэг бодис буюу зүйл гэж өргөн утгаар нь тодорхойлдог. *Илүү дэлгэрэнгүй тодорхойлолтыг Рио Тинтогийн Е5: Аюултай материал ба бохирдлын хяналтын удирдамжаас харна уу.*

Хор аюулын лавлах мэдээлэл (ХАЛМ): ХАЛМ гэж химийн бодистой харьцах, ажиллах үеийн хэрэгтэй мэдээлэл, журмыг тодорхойлсон бичиг юм. Хүчин төгөлдөр ХАЛМ нь тухайн бодисын физик болон химийн шинж чанар, болзошгүй аюулын талаарх мэдээлэл, яаралтай үед авах арга хэмжээ, үйлдвэрлэгчийн холбоо барих дугаар зэргийг тусгасан байдаг.

Хаалт далан: Хаалттай хэсгээс хортой шингэн гадагшлахаас сэргийлж барьсан хана, тусгаарлагч юм.

Хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ): гэж осол гэмтэл, өвчлөлөөс хүнийг хамгаалах зориулалттай хувцас хэрэглэл, тоног төхөөрөмж, бодис юм.

6 АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

Төслийн үйл ажиллагаанд хамааралтай Аюултай материалтай ажиллах Монгол улсын стандартууд нь дараах болно. Үүнд:

- 2006 онд батлагдсан Химийн хорт болон аюултай бодисын тухай Монгол улсын хуулиар Аюултай материалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулдаг. Түүнчлэн ус нь аливаа нөлөөлөлд өртөж болох тул усны чанарын стандарт (MNS 4586:98) нь чухал ач холбогдолтой юм.
- Химийн хорт болон аюултай бодисын импорт, экспорт, хил дамжуулан тээвэрлэлт, худалдаанд тавих журам (Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад хэргийн сайдын 334/104 дугаар хамтарсан тушаалын хавсралт)
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 28/40/29 дүгээр хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт “Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, зарцуулалт, хадгалалт, устгалын журам”
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 28/40/29 дүгээр хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт “Химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ хийх журам”
- 2007 оны Засгийн газрын 95-р тогтоолоор баталсан “Монгол улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт”
- Аюултай материалыг ашиглахдаа Монгол улсын Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль болон түүнд заасан тайлагнах шаардлагын дагуу ашиглана. (9.1-р зүйл)
- ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага (2008) (ялангуяа PR1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ, менежмент болон PR3: Бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах шаардлага)
- ОУСК-ийн Уул уурхай дахь Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамж 2007
- ОУСК-ийн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ерөнхий удирдамж 2007

Аюултай материалын менежментэд хамааралтай нэн тэргүүний Рио Тинтогийн стандарт нь 2008 онд боловсруулсан Е5 – *Аюултай материал болон бохирдлын хяналтын стандарт юм.*

Рио Тинтогийн холбогдох бусад баримт бичиг:

Аюултай материалын менежментийн журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.06.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е5-PRC-0001-М	Хувилбар: 2.0

- В4 Аюултай бодисын стандарт (Хөдөлмөрийн эрүүл мэнд);
- E2 Агаарын чанарын хяналтын стандарт
- E9 Газар ашиглалтын удирдлагын стандарт
- E10 Ус ашиглалт, чанарын хяналтын стандарт

7. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Баримт бичгийн нэр	ОТ-10-Е5-PRC-0001-М-Аюултай материалын менежментийн журам_v2.0
Тайлбар	Аюултай материалын менежментийн журам
Эх зохиогч(д)	Пол Гербер, Баасансүрэнгийн Долгор, Санжмятавын Мөнгөнчимэг, Марк Ньюби.
Боловсруулсан огноо	2012.08.15
Баталсан	Пол Гербер, Эрүүл мэндийн менежер Марк Ньюби, Байгаль орчны менежер
Баталсан огноо	2012.09.10
Өөрчлөлт оруулсан дугаар	##

Эрсдлийн түвшин	Үнэлгээ хийсэн Огноо	Эрсдлийн үнэлгээ хийсэн	Хяналт хийх давтамж	Дараагийн хяналт хийх огноо
Дундаж	2013.06.01	Баасансүрэнгийн Долгор	2 жилд нэг удаа	2015.06.01

Хувилбар	Өөрчлөлт оруулсан огноо	Зохиогчид	Баталсан	Өөрчлөлтийн тайлбар
1.0	2012.08.15	Пол Гербер, Баасансүрэнгийн Долгор, Санжмятавын Мөнгөнчимэг, Марк Ньюби	Пол Гербер, Марк Ньюби	Анхны хувилбар
2.0	2013.06.01	Марк Ньюби.	Марк Ньюби.	Санхүүжүүлэгч байгууллагын тавьсан шаардлагуудад нийцүүлэн өөрчлөлт оруулав.